



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

### Олон улсын хурал зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хамтын ажиллагааны Коломбын төлөвлөгөө” байгууллагын Зөвлөлдөх хорооны 48 дугаар хурлыг 2024 оны 05 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсугай.

2.Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хамтын ажиллагааны Коломбын төлөвлөгөө” байгууллагын Зөвлөлдөх хорооны 48 дугаар хурлыг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Хурлын бэлтгэл ажлыг өндөр түвшинд зохион байгуулж, хурлын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг 2024 оны батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаярт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

Б.ЭНХБАЯР

Засгийн газрын 2024 оны 04 дүгээр  
сарын 17-ны өдрийн 158 дугаар  
тогтоолын хавсралт

**“АЗИ, НОМХОН ДАЛАЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ КОЛОМБЫН ТӨЛӨВЛӨГӨӨ” БАЙГУУЛЛАГЫН ЗӨВЛӨЛДӨХ  
ХОРООНЫ 48 ДУГААР ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ахлагч: -Б.Энхбаяр-Хууль зүй, дотоод хэргийн сайд
- Дэд ахлагч: -Г.Амартүвшин-Гадаад харилцааны дэд сайд
- Гишүүд: -Б.Солонгоо-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;
- Ж.Мөнхболд-Ерөнхийлөгчийн Тамгын газрын  
Хууль, эрх зүйн газрын дарга;
- Н.Мягмар-Хууль зүй, дотоод хэргийн яамны  
Төрийн нарийн бичгийн дарга;
- Х.Батжаргал-Боловсрол, шинжлэх ухааны яамны  
Төрийн нарийн бичгийн дарга;
- Д.Очирбат-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн  
бичгийн дарга;
- Б.Алимаа-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын  
яамны Төрийн нарийн бичгийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын  
албаны төлөөлөл (зөвшилцсөнөөр);
- Н.Ууганбаяр-Гадаадын иргэн, харьяатын газрын  
дарга;
- Ц.Ням-Очир-Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн  
дэд дарга;
- С.Хүдэрчулуун-Тагнуулын ерөнхий газрын дэд  
дарга;
- Г.Энхтайван-Гаалийн ерөнхий газрын дэд дарга;
- Л.Нямгэрэл-Хууль зүй, дотоод хэргийн яамны  
Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Д.Гантуяа-Хууль зүй, дотоод хэргийн яамны  
Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга;

-Ч.Амарбаясгалан-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч;

-Ц.Мягмардорж-Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх газрын дарга.

Нарийн бичгийн  
дарга:

-Ч.Нарантуяа-Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын дарга.

----oOo----